

2.14. Ф. НИЦШЕГИЙН БОЛОВСРУУЛСАН “МӨНХИЙН БУЦАЛТ” ГЭДЭГ ФИЛОСОФИ БАРИМТЛАЛЫГ ШИНЖЛЭХ НЬ

*Түлхүүр үгс: Мөнхийн буцалт, Тэр л юм Өөрөөгийн буцалт, Үлэмж хүн,
Ганцаараа, Хаягдмал*

Оршил хэсэг

XX зууны философийн зарим төлөөлөгч “мөнхийн буцалт” гэдэг Ф.Ницшегийн баримтлалыг нэлээд бүдүүвчлэн тайлбарлаж иржээ. Жишээ нь Пифагор, Гераклит, стоикчууд, Лукреций гэх мэт эртний Грек, Ромын сэтгэгчдийн бүтээлийг маш сайн эзэмшсэн сонгодог филологийн профессор Ф.Ницше тэдний ярьсан мөнхийн буцалтыг өөрийн өвөрмөц санаа болгон ярьсанд хачирхаж байгаагаа А.Фулье илэрхийлсэн хэмээн оросын философич Т.Г.Румянцева “Мөнхийн буцалт” гэдэг томоохон өгүүлэлдээ бичсэн байдаг билээ¹. Өөрөөр хэлбэл Ф.Ницшегийн “мөнхийн буцалт” гэдэг санаа бол эртний грекчүүдийн “мөнхийн буцалт” хэмээх сэтгэлгээг давтсанаас хэтрээгүй гэж А.Фулье үзсэн аж.

Түүнээс гадна зарим философич “мөнхийн буцалт”-ын тухай Ф.Ницшегийн баримтлалыг үлэмж хүний тухай түүний философи баримтлалтай, өөрөөр хэлбэл байнга урагшаа тэмүүлж, шинийг бүтээж байхыг сурталчилдаг онолын баримтлалтай логик зөрчилтэй гэдэг аж.

Харин бидний судалгааны үр дүнгээс үзвэл Ф.Ницшегийн дэвшүүлсэн “мөнхийн буцалт” гэдэг философи баримтлал бол энэ сэтгэгчийн өвөрмөц бүтээл, улмаар уг баримтлал бол үлэмж хүний тухай онолтой авцалддаггүй биш, харин нягт уялддаг байна.

Нэг. “Мөнхийн буцалт” гэдэг Ф.Ницшегийн философи баримтлалын агуулга

Ф.Ницше “Заратустра ингэж өгүүлэв” зохиолынхоо үндсэн баримтлалыг юу болохыг “Ессе Ното” бүтээлдээ дурдахдаа энэ баримтлал бол “мөнхийн буцалтын тухай сэтгэлгээ, бататгалын энэхүү дээд хэлбэр... мөн”² гэсэн байдаг.

Ф.Ницшегийн “Заратустра ингэж өгүүлэв” зохиолын гуравдугаар хэсгийн төгсгөл нь: “Долоон тэмдэглээ буюу Тийм, Амен хоёрын тухай дуудал” гэдэг нэр бүхий уянгын өгүүллэг билээ. Энэ өгүүлэлийн 4 дэх тэмдэглээнд:

“Хэрвээ миний гар аль нэгэн үед хамгийн холыг хамгийн ойр луу, галыг сэтгэл рүү, баяр хөөрийг зовлон руу, хамгийн мууг хамгийн шилдэг рүү сэлбэсэн бол, -
-Хэрвээ бүх юмыг савтай хольцонд сайн холиход хүргэх ариутгалын давсны ширхэг би өөрөө болж байвал, -Аяа, яагаад би Мөнх шинж рүү болон гархинуудын хэлхээ гархи руу улайран тэмүүлэхгүй билээ?”³ гэсэн мөрүүд байдаг билээ
Эндээс үзвэл хүний үйлдэл нь:

- холыг зорьсон;
- гал халуун сэтгэлтэй;
- баяр хөөрийг биш, харин зовлонг дээдэлдэг;
- шилдэг сайн

тус тус байх ёстой.

Ф.Ницшегийн онцолж буй эдгээр шинж бол Заратустрагийн үг, үйлдлийг тодорхойлж байдгийг “Заратустра ингэж өгүүлэв” зохиолтой танил болсон уншигч анзаарах үндэстэй.

“Заратустра ингэж өгүүлэв” зохиолын гуравдугаар хэсэг дэх “Буцалт” гэдэг гарчигтай өгүүллэгт ёс суртахуун, үнэлэмж хоёр бодгаль онцлогтой байх ёстой гэсэн санааг илэрхийлсэн байдаг. Үүнд, тэнд бичихдээ: “...аяа, ганцаардал аа! Чи бол миний эцэг орон шүү ганцаардал аа! Би чам руу нулимстай буцаж ирэхгүйн тулд зэрлэг харь нутагт зэрлэг байдлаар дэндүү олон жил амьдарлаа...”

Аяа, Заратустра, миний дэргэд ганцаар байсан үеэ бодвол олны дотор чи илүү хаягдмал байсан тэр бүгдийг би мэднэ шүү.

Хаягдмал байх нэг хэрэг, ганцаардал өөр хэрэг. Чи хүмүүсийн дунд ямагт зэрлэг, харийн хүн байдаг. Үүнийг одоо чи мэдэж авсан”⁴. “Араатны дунд байснаас хүмүүсийн дунд байх аюултай буй энэ л хаягдмал байдал мөн”⁵ гэж буй.

Тийнхүү Ф.Ницше энэ өгүүллэгтээ ганцаардлын буцалт бол “нулимсгүй буцалт” мөн гэжээ. Энэ нь ганцаардал бол хаягдал биш, харин ирээдүйн зөгнөл, түүний ирэлт бол олон түмэнд үл захирагдагч, тиймээс тэдэнд үл таашаагдагч ирэлт буюу буцалт мөн гэж үзсэн үзэл ажээ.

“Заратустра ингэж өгүүлэв” зохиол дахь “Долоон тэмдэглээ буюу Тийм, Амен хоёрын тухай дуулал” гэдэг уянгын өгүүллэгийн 7 бадаг тус бүр нь “Би дурлаж байна гэж буй тийм хүүхнээсээ бусад эмэгтэйгээс бол намайг хүүхэдтэй болгож өгөөсэй гэж би хүсдэг эмэгтэйтэй би хэзээ ч хараахан учраагүй байна. Яагаад гэвэл аяа, Мөнх, чанар минь, би чамд хайртай” гэсэн төгсгөлтэй буй.

Тийнхүү Ф.Ницше Мөнх чанарыг зөвхөн ганцаараатай л холбожээ.

*Хоёр. “Мөнхийн буцалт” гэдэг Ф.Ницшегийн
баримтлалд өгсөн зарим философичийн
ээрэг үнэлгээ*

XX зууны өндөр нэр хүндтэй зарим философич “мөнхийн буцалт” гэдэг Ф.Ницшегийн философи баримтлалыг эерэгээр үнэлж иржээ.

Энд германы экзистенциалист философич М.Хайдеггерийн үнэлгээг эхлээд авч үзье. Тэрээр Ф.Ницшегийн өвөрмөц сэтгэлгээнүүдийг авч үзэхдээ өөрийнхөө философид боловсруулсан “ахуй”, “байгаа” гэдэг ойлголтуудыг ашигласан юм⁶. Түүний хувьд байгаа бол өөрийнхөө ахуйд хамаарч, ахуйдаа даатгагдагч мөн. Харин ахуй бол байгаад өөрт нь холбогддог тийм үйл хэрэг мөн. Тийнхүү тэрээр “байгаа”, “ахуй” гэдэг ойлголтуудаар сонгодог онтологид ярьдаг ямар нэг объект буюу субстанци ба түүний оршихуйг биш, харин Би ба түүний оршихуйн аргыг илэрхийлдэг.

М. Хайдеггерийн оношоор бол Ф.Ницшегийн философи дахь “мөнхийн буцалт” гэдэг ойлголт нь “эзэрхэх хүсэл эрмэлзэл” гэдэг түүний өөр нэг үндсэн философи баримтлалтай холбоотой. Ф.Ницшегийн хувьд эзэрхэх хүсэл эрмэлзэл бол байгаа бүхний гол шинж мөн гэж М.Хайдеггер дүгнэжээ. Тэгээд М.Хайдеггер үзэхдээ: Ф.Ницше чухамхүү “мөнхийн буцалт” гэдэг ойлголтоороо дамжуулж байж байгаа чухам яаж оршдог вэ? гэдгийг нотлохыг оролдсон бөгөөд бас түүний “мөнхийн буцалт” гэдэг ойлголт нь “үлэмж хүн” гэдэг ойлголттой нь холбогдож байж гагцхүү энэ “эзэрхэх эрх мэдэл” гэдэг ойлголтоор нь дамжин хэрэгжинэ гэсэн аж⁷.

Ф.Ницшегийн философийг судалсан францын философич Ж.Делёзийн үйл ажиллагаанд “мөнхийн буцалт”-ын тухай баримтлалын талаархи дүгнэлтүүд чухал байр суурь эзэлдэг аж. Тэрээр уг дүгнэлтүүдээ хийхдээ өөрийнхөө боловсруулсан “ялгаа ба давталт” гэдэг философи баримтлалыг ашигласан байна⁸.

Ж.Делёз 1965 онд “Ницше” гэдэг ном хэвлүүлжээ. Тэрээр эл бүтээлдээ: “Мөнхийн буцалт”, “Тэр л Юмны Өөрийнх нь буцалт” хоёрыг адилтгаж болохгүй гэсэн нь “буцалт бол бүрэлдлийн ахуй мөн” гэдэг үзлийнхээ үүднээс өгүүлсэн санаа юм. Хэрэв энэ хоёрыг адилтгаваас үнэлэмжүүдийн шинэчлэх хэлбэрийг гуйвуулдаг. Тэр л Юм Өөрөө буцдаггүй, харин бүрэлдэл бол цорын ганц буцалт байдаг. Иймд бүрэлдлийг бас Ганц гэж болно. Өөрөөр хэлбэл Ф.Ницшегийн хувьд гагцхүү ялгаатай юм буюу өөр юм болж бататгадаг хүсэл эрмэлзэл л буцдаг. Тийм учраас буцалт бол

ялгарах, шинэчлэгдэх, байгаа бүхний дээд хэлбэрийг эрх чөлөөтэй болгох -энэ бүхний буцалт ямагт мөн.

Эндээс үзвэл Ф.Ницшегийн философи дахь Мөнхийн буцалт бол эртний Дорно, Өрнийн сэтгэлгээн дэх орчлын загварын хуулбар биш гэж Ж.Делёз нотолдог. Тухайлбал Гераклитийн үзлээр оршин буй бүхний хувьд нэг л юм байж өгдөг орчлон (космос)-г ямар ч бурхан тэнгэр, ямар ч хүн бүтээгээгүй. Орчлон бол хэмээр асаж, хэмээр унтарч байдаг мөнхийн амьд гал ямагт байсан, байгаа, байх ч болно. Дэлхийн үйл явц орчилт шинжтэй. Өөрөөр хэлбэл “аугаа он жил” өнгөрөхөд юм бүхэн дахиад “гал” болж буцдаг⁹.

Өөрөөр хэлбэл Ж.Делёзийн нэр томъёог ашиглан дүгнэж хэлэхэд Тэр л Юм Өөрөө буцдаг тухай Гераклит өгүүлжээ. Үүнд: Гераклит “оршин буй бүхний хувьд нэг л юм байж өгдөг” буюу оршин буй бүхэнд түгээмэл ач холбогдолтой тийм зүйлийн буцалтын тухай өгүүлжээ. Ийнхүү (Гераклит гэх мэт) эртний сэтгэгчдийн ярьсан орчилт буцалтыг Ф.Ницше огтхон ч давтаагүй, хуулбарлаагүй байна. Эртний сэтгэгчдийн ярьсан буцалт бол Ф.Ницшегийн сэтгэн илэрхийлсэн онцгойгийн, ганцаараагийн буцалт биш, харин төсөөний орчил, орчин үеийн хэллэгээр байгалийн хууль мөн.

Гэхдээ “Заратустра ингэж өгүүлэв” зохиолд мөнхийн буцалтын талаар хоёр тайлбар байдаг гэж Ж.Делёз бичсэн байна. Тэр хоёр тайлбарын нэг нь Заратустрад бүргэд, могой зэрэг амьтад нь гаргасан тайлбар, тэхдээ Заратустраг өвчтөн болгоход хүргэсэн тайлбар мөн. Тэдгээр амьтад Заратустрад учирласан энэ тайлбар ёсоор “аливаа юм бүжиглэдэг. Үүнд: бүгд л ирж, бие биетэйгээ гар барьж, инээлдэж, холдон одож, улмаар бас буцан ирдэг. Бүгд явж, бүгд буцан ирдэг бөгөөд ахуйн дугуй мөнхөд буцдаг. Бүгд үхэж, бүгд дахин цэцэглэж, ахуйн он жил мөнхөд цувдаг.

Бүгд сүйдэж, бүгд дахин төвхнөж, ахуйн тэр л оромж мөнхөд босдог. Бүгд салж, бүгд дахин бие биетэйгээ мэндчилж, ахуйн дугуй өөртөө мөнхөд үнэнч үлддэг.

Агшин бүрт ахуй эхэлж, аливаа “энд”-ийн эргэн тойронд бас “тэнд” бөмбөрч байдаг. Төв нь газар сайгүй. Муруй бол мөнх шинжийн зам мөн”¹⁰.

Мөнхийн буцалтыг ойлгох чухам ийм ойлгоц сэтгэлд нь орсноор Заратустра бие нь бүтэн долоо хоног муудсан хэмээн Ф.Ницше “Заратустра ингэж өгүүлэв” зохиолынхоо гуравдугаар хэсэг дэх “Илааршигч” гэдэг өгүүлэлд бичсэн буй¹¹.

Угтаа ийм маягийн буцалт бол мөнхийн буцалт биш, харин Тэр л юм Өөрөөгийн буцалт мөн. Энэ бол эртний сэтгэгчдийн илэрхийлсэн орчилт загварын буцалт юм.

Ийм төрлийн буцалтыг Ф.Ницше улиг болсон, аймшигт таамаглал (гипотез) гэж үзсэн талтай. Яагаад гэвэл уг таамаглал байгалийн ба амьдралын шууд бодит байдалд зохицож, эртний сэтгэлгээн дэх орчлын тухай баримтлалыг сэргээдэг.

Энэ дүгнэлтийг үндэслэх нэг зүйл иш татахад Заратустра өөрийнхөө амьтдыг мөнхийн буцалтын тухай (дээр дурдсан) тайлбараа таниулахад нь:

“-Аяа, та нар бол зүггүй бодолтон, уран гоё донгодогч нар юм.

-Долоо хоногт юу хийж болох вэ гэдгийг

-бас аймшигт хорхой миний хоолой руу хэрхэн гулсан орж, намайг сандаргасныг та нар яасан сайн мэддэг юм бэ? Гэхдээ би тэр хорхойны толгойг тас хазаад өөрөөсөө хол нулимчихсан.

Харин та нар бол үүнээсээ та нар гудамжны дуу зохиож амжаа юу?”¹² гэж хариулан шоолдог билээ. Ф.Ницше мөнхийн буцалтын тухай эл ойлгоцыг бас жижиг хүмүүсийн ойлгоц гэж үнэлсэн юм¹³.

Мөнхийн буцалтын тухай Заратустрагийн амьтдын илэрхийлсэн тайлбарыг Ф.Ницше аймшигтай таамаглал гэж үзсэн тухай өмнө дурдсан билээ. Яагаад гэвэл Ж.Делёзийн нэр томъёогоор хэлэхэд хэрвээ Тэр л Юм Өөрөө үнэхээр буцдаг бол жижиг, өрөвдөлт хүн бас буцдаг байж таарна. Чухам ийм үйл явдал гарахаас айдаст автсан Заратустра: “Пээ, хүн мөнх буцах нь. Жижиг хүн мөнх буцах нь!

Би нэг удаа хамгийн том, хамгийн жижиг хоёр хүнийг хоёуланг нь шав шалдан байгааг харсан. Тэгэхэд тэд бие биетэйгээ дэндүү төстэй, бүр хамгийн том хүн нь хүртэл бас дэндүү бага хүн байв.

Хамгийн том нь дэндүү бага байв. Энэ нь хүнийг миний жигшсэн нь байлаа! Бүр хамгийн бага хүний мөнх буцалтыг ээ хөөе! Энэ бол аливаа оршихуйд миний хуншгүй ханддаг нь юм.

Пээ, жигшмээр юм! жигшмээр юм! жигшмээр юм!”¹⁴ хэмээн ихэд дуу алдаж байдаг.

Заратустра өвчнөө илаарших үедээ Мөнхийн буцалт бол Тэр л Юм Өөрөөгийн буцалт мөн гэж үзэхийнхээ бурууг ийнхүү анзаарч эхэлдэг. Тэгээд тэрээр Мөнхийн буцалт бол үлэмж хүн бүхнээс хүчтэйг бататгагч шилэлтийн үйл явц мөнхийг ухаардаг. Өөрөөр хэлбэл Мөнхийн буцалт бол шинийг “мөнхөд бүтээн бататгахуй” мөн бөгөөд тийнхүү тэр л юм өөрөө биш, харин зөвхөн ганцыг, ялгааг, бүтээхүйг бүрдүүлэгч бататгал л буцдаг болохыг Заратустра ухаарч эхэлдэг. Зартустрагийн энэхүү

сэхээрэл бол Ф.Ницшегийн үзлийг илэрхийлж байдаг нь “Заратустра ингэж өгүүлэв” зохиолыг ойлгодог болсон хүнд мэдээж юм.

Мөнхийн буцалтын тухай Ф.Ницшегийн сэтгэлгээ бол амьдралын бүрэлдлийг амьдралын өөрийнх нь ялгарал ба олон янз байдлын үр шим гэж үздэг үзэл мөнийг М.Хайдеггер, Ж.Делёз нар өгүүлсэн билээ. Тийнхүү Мөнхийн буцалт бол амьдралын төгөлдөржилтийн дээд хэлбэр мөн гэж Ф.Ницше сурталчилжээ.

Мөнхийн буцалтын тухай Ф.Ницшегийн баримтлалын үүднээс хандвал ямар нэг (христос шашны, либераль, коммунист гэх мэт) ерөнхий ёс суртахууны тогтолцоонд үндэслэдэг утга учир, зорилго бүхий амьдрал байх боломжгүй юм.

Ф.Ницшегийн философидолтийн стиль нь, философийн зориулалт юу болох тухай түүний тайлбар нь амьдралын тухай философийн өөрөөс нь хойшхи төлөөлөгч нарт төдийгүй экзистенциализм, улмаар постструктуралист ба постмодернист философидолт зэрэгт хүчтэй нөлөөлсөн ажээ.

Резюме

В данной статье с заглавием “Анализ философской концепции о вечном возвращении, разработанной Ф.Ницше” раскрывается содержание теоретической концепции Ф.Ницше о вечном возвращении. Автор статьи указывает несостоятельность отождествления понятий Ф.Ницше и древнегреческих мыслителей, выражающихся словосочетанием “вечное возвращение”. Причём в этой статье рассматриваются анализы М.Хайдеггера и Ж.Делёза, относящиеся к оценкам ницшевской концепции о вечном возвращении.

НОМ ЗҮЙ

1. См. об этом: Постмодернизм. Энциклопедия. Мн., 2001 с.116
2. Фридрих Ницше. Сочинения в двух томах. Т.2, с.743
3. Там же, с. 167-168
4. Там же, с.131
5. Там же, с.132
6. М.Хайдеггер эдгээр ойлголтынхоо агуулгыг илэрхийлсэн гол бүтээл нь: М.Хайдеггер. Бытие и время. М., 1997, с.41-42
7. “Мөнхийн буцалт” гэдэг Ф.Ницшегийн философи ойлголтын талаархи М.Хайдеггерийн дүгнэлтүүдийг товч, оновчтой илэрхийлсэн нэг бүтээлийн

холбогдох хуудсуудыг дурдахад: Т.Г.Румянцева. Вечное возвращение. – Постмодернизм. Энциклопедия. Мн. 2001, с.115-117

8. Энэ баримтлалын тухай: Ц.Гомбосүрэн. Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт (Постструктурализм, постмодернизм) УБ.,2002, 96-98 дахь талд үзнэ үү.
9. Гераклитийн томъёолсон орчлын үзлийг оновчтой, товч илэрхийлсэн нэг өгүүллийг дурдахад: В.Ф.Асмус. Гераклит.-Философский словарь. Под ред. И.Фролова. 7-е изд, перераб. и доп. М.,2001, с.119
10. Фридрих Ницше. Сочинения двух томах. Т.2, с.158
11. Там же, с. 156-157
12. Там же, с.158
13. См. об этом напр.:с.159
14. Там же, с.159-160